

E-9 Гадаад ажилчин Нас барсан хэргийн зохицуулалт ба оршуулгын тусламж үзүүлэх зааварчилгаа

БНСУд оршин суух үедээ нас барсан гадаад ажилчны зохицуулалт ба оршуулгын үйл явц ба оршуулгын зардлын тусламж

1 Хэрэг мэдэгдэх

Харьяа цагдаагийн газар · Хөдөлмөрийн биржс · БНСУд байх элчин сайдын яам

- **Ажил олгогч**
  гадаад ажилчин нас барвал цагдаагийн газар (119 орно) ба хөдөлмөрийн биржид мэдэгдэнэ
- **Цагдаагийн газар ба хөдөлмөрийн биржс**
  БНСУд байх элчин сайдын яаманд нас барсан тухай мэдэгдэн, талийгаачийн ар гэр хүрч ирэх ба итгэмжлэх (гадаад ажилчны байгууллага) үйл явцыг гүйцэтгэнэ.

2 Хэргийн газар шалгалт хийх

Хэргийн үйл явц, шалтгаан · Гэрчийн мэдүүлэг

- Цагдаагийн газраас хэргийн газар хийсэн шалгалтын үр дүнг ажил олгогч ба БНСУд байх ажиллах хүч гаргасан улсын элчин сайдын яаманд (талийгаачийн ар гэр)мэдэгдэн, хөдөлмөрийн биржс нь холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

Байдал	Хариуцах газар	Тусламж
Үйлдвэрлэлийн ослын хэрэг	Хөдөлмөр нийгмийн халамжийн газар	Үйлдвэрлэлийн ослын даатгалын нөхөн төлбөр олгоно (дундаж цалин 1300өдрийн хэмжээтэй)
Ослын хэрэг	Самсунг даатгал	ослоор нас барсны нөхөн төлбөр (дээд талнь 30сая вон)
Өвчний хэрэг	Самсунг даатгал	өвчнөөр нас барсны нөхөн төлбөр (дээд тал нь 15сая вон)
Амиа · хорлох тодорхой шалтгаангүй нас барсан	БНСУд байх ажиллах хүч гаргасан улсын элчин сайдын яам	(оршуулгын компани) оршуулгын ёс горимыг үйлдэнэ * нотлох бичиг баримт орно (байгууллага) оршуулгын төлбөр нэхэмжилнэ
	АҮХНГ	нэхэмжилсэн зардал олгоно (3сая воны дотор 14 хоногийн дотор олгоно)

3 Оршуулгын ёс горим үйлдэх

Талийгаачийн ар гэрийнхэнтэй зохицох · Чандарлах, чандар эдэлж байсан зүйлсийг цэгцлэх · Шарилыг эх оронд нь буцаах

- БНСУд байх ажиллах хүч гаргасан улсын элчин сайдын яам (мөн итгэмжлэгдсэн байгууллага) нь талийгаачийн ар гэрээс чандарлах ба шарил шилжүүлэх шаардлагын бичиг авч талийгаачийн ар гэрийн шийдвэрийн дагуу сонгосон оршуулгын компаниар дамжуулан талийгаачийн шарилыг шилжүүлнэ.

Талийгаачийн ар гэрээс ажил хэргийг зохицуулах (оршуулга) зардал гаргах боломжгүй бол БНСУд байх ажиллах хүч гаргасан улсын элчин сайдын яам тус бүрээс гаргасан мөнгөн тусламжийн хэмжээ мөрдөгдөнө

Оршуулга	Чандарлах	Муудахаас хамгаалах	Чандар эх оронд нь буцаах	Шарил эх оронд нь буцаах
(2сая орчим)	(100000вон~1сая вон)	(2сая 500000 вон ~5сая вон)	(400000вон~1сая вон)	(600000вон ~1сая500000 вон)

4 Даатгал ба цалин олгох

Ажилласан цалин · Гадаад ажилчин Зориулалтын даатгал

- Нас барсан байдлаас хамааран тухайн байгууллагаас олгох даатгалын нөхөн төлбөр ба бусад цалин, буцах зардал •13дах сарын цалингийн даатгал, нийгмийн даатгал (хамрагдсан бол)ыг олгоно

даатгалын нөхөн төлбөрийн хүсэлт гаргах : ажил олгогч, БНСУд байх ажиллах хүч гаргасан улсын элчин сайдын яам , талийгаач ар гэр (мөн талийгаачийн ар гэрээс итгэмжилсэн байгууллага)зэрэг

13дах сарын цалингийн даатгал	Буцах зардлын даатгал	Цалинг нөхөн олгох баталгааны даатгал	Цалин	Тэтгэврийн даатгал
(хамрагдсанаас хойш 1жил өнгөрсөн)	(улс тус бүр 400000~600000 воны хязгаартай)	(цалин олгоогүй бол 2сая воны хязгаартай)	(ажилласан хугацаагаар тооцно)	(хамрагдсан бол)

고용노동부 한국산업인력공단 HUMAN RESOURCES DEVELOPMENT SERVICE OF KOREA



Амиа хорлох · учир шалтгаангүй нас барсан оршуулгын тусламж

Үйл ажиллагааны гол зүйл

- БНСУд оршин сууж буй гадаад ажилчид дотроос амиа хорлох ба учир шалтгаангүй нас барсан бол оршуулгын үйл явцад шаардагдах зардлыг 3сая воны хэмжээнд бодит оршуулгын зардлыг өгдөг систем юм.

Тусламж олгох этгээд

- E-9 визтэй амиа хорлосон ба учир шалтгаангүйгээр нас барсан гадаад ажилчин

Тусламжийн зардал

- 3сая воны дотор
  * Чандарлах, муудахаас хамгаалах, шарил эх оронд нь буцаах зэрэг бодитоор зарцуулсан оршуулгын зардлаар хязгаарлах ба, дээд тал нь 3сая воны хязгаартай

Тусламжийн мөнгө хүсэлт гаргах ба олгох

- Хүсэлт гаргах газар : Солонгосын аж үйлдвэр хүний нөөцийн газрын ажил олгох хэсэг
- Х үсэлт гаргах байгууллага : БНСУд байх ажиллах хүч гаргасан улсын элчин сайдын яам

Оршуулгын үйл явцыг гүйцэтгэсний дараа оршуулгын тусламжийн мөнгөний хүсэлт ба нотлох баримтыг хавсарган Солонгосын аж үйлдвэр хүний нөөцийн газарт оршуулгын зардал нэхэмжилнэ

Гаргах бичиг баримт

- **Оршуулгын зардал**
  оршуулгын тусламжийн мөнгө хүсэлт гаргах бичиг, нас барсан тодорхойлолт эсвэл задлан шинжилгээний бичиг, оршуулгын зардлын баримт, хадгаламжийн дэвтрийн хуулбар(БНСУд байх ажиллах хүч гаргасан улсын элчин сайдын яаманд олгох бол), Оршуулгын компанийн гэрчилгээн ба хадгаламжийн дэвтрийн хуулбар (компанид олгох бол)
- **Шарилыг эх оронд нь буцаах**
  оршуулгын тусламжийн мөнгө хүсэлт гаргах бичиг, талийгаачийн хилээр гарахыг (урьдчилсан) батлах бичиг, муудахаас хамгаалсан бичиг

Холбогдох байгууллагын утас

Байгууллагын нэр	хариуцсан ажил	утас
Хөдөлмөрийн бирж	Үйлдвэрлэлийн ослыг шалгах	☎ 1350
Хөдөлмөрийн нийгмийн халамжийн газар	Үйлдвэрлэлийн ослын даатгалын мөнгө олгоно	☎ 1588 - 0075
Нийгмийн даатгалын газар	Нийгмийн даатгал нөхөн төлбөр нэгмөсөн олгоно	☎ 1355
Самсунг даатгал	13сарын цалин · буцах зардлын даатгалын нөхөн төлбөр олгоно	☎ 02 - 2261 - 8400
Гадаад ажиллах хүчинд зөвлөгөө өгөх төв	Орчуулга · зөвлөгөө өгөх Амиа хорлогчийн оршуулгын зардалын тусламжийг танилцуулах	☎ 1577 - 0071



고용노동부 한국산업인력공단 HUMAN RESOURCES DEVELOPMENT SERVICE OF KOREA